# НИЙГМИЙН ДААТГАЛЫН ҮНДЭСНИЙ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

2018 оны 04 сарын 17 өдөр | Дугаар 03 | Улаанбаатар хот

Нэрийн дансны 2017 оны орлогод тооцох хүүгийн хэмжээг тогтоох тухай

Тэтгэврийн даатгалын шимтгэлийн нэрийн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3 дахь хэсэг, Үндэсний статистикийн хорооны 2018 оны 01/02 дугаар албан бичгээр ирүүлсэн саналыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Даатгуулагчдын тэтгэврийн даатгалын шимтгэлийн нэрийн дансны 2017 оны орлогод тооцох жилийн хүүгийн хэмжээг 6.7 хувиар баталсугай.

2. Баталсан хүүгийн хэмжээг үндэслэн даатгуулагчдын тэтгэврийн даатгалын шимтгэлийн нэрийн дансны орлогод хүү тооцох, нэрийн дансны мэдээлэх хуудсыг даатгуулагчдад хүргүүлэх ажлыг 2018 оны 02 дугаар улиралд багтаан зохион байгуулахыг Нийгмийн даатгалын ерөнхий газар /Д.Зоригт/-т даалгасугай.

3. Энэ тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Нийгмийн даатгалын Үндэсний зөвлөлийн Ажлын алба /Р.Отгонжаргал/-нд даалгасугай.

ДАРГА С.ЧИНЗОРИГ

1116125031 ... 5284703

D:\Togtool folder\2018.docx

1000007